



## ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/384

Хэрлэн сум


### Олон улсын тэмцээнд монгол улсаа төлөөлөн оролцоход дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 8.1.3 дахь заалт, "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор өндөр сумын харьяат иргэн Н.Бадамхандаас ирсэн хүсэлтийн дагуу тамирчин Г.Дөлгөөндалай, Э.Гоо нарт Япон улсад зохион байгуулагдах 15 дахь удаагийн азийн аварга шалгаруулах тийболлын олон улсын тэмцээнд монгол улсаа төлөөлөн оролцоход нь 10,000,000 (арван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн "Нийтийг хамарсан үндэсний болон нийтийн биеийн тамир, бүх нийтийн спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг түшиглэн биеийн тамираар хичээллэгсдийг нэмэгдүүлнэ" арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Баярбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ